

II. Монголч эрдэмтдийн VIII их хурал болон бусад олон улсын бага хуралд тавьсан илтгэл

**90 -ЭЭД ОНООС ХОЙШХИ ҮЕИЙН ОРОС-МОНГОЛ,
ХЯТАД-МОНГОЛЫН ХАРИЛЦАА**

**МУИС, ОУХС-ийн захирал
профессор, доктор (Ph.D) Н.Алтанцэцэг**

XX зууны сүүлийн 10 жилийг Монгол улсын гадаад харилцааны эргэлтийн үе гэж тодорхойлж болно. Монгол улс ардчилал, зах зээлийн системд шилжих болсноор бие даасан гадаад бодлого явуулж, дэлхийн олон орон, байгууллага, бүс нутагтай харилцаж гадаад харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж байна. Хэдий тийм боловч Монгол улс газар зүйн байршлын хувьд Орос, Хятадын дунд оршдог учир Монгол улсын гадаад харилцаанд хоёр хөрштэй харилцах харилцаа чухал байр эзэлдэг бөгөөд хойшид ч эзлэх болно.

Хувьсан өөрчлөгдөж буй олон улсын харилцааны чиг хандлага Орос-Монгол, Хятад-Монголын харилцаанд ч тусгалаа олж байгаа бөгөөд хоёр хөршийн Монгол улстай харилцах харилцаанд анхаарлаа хандуулж, харьцуулсан дүгнэлт хийхийг зорив.

Орчин үеийн Орос-Монгол, Хятад-Монголын харилцаанд тухайн улс бүрийн нийгэм, улс төр, эдийн засагт гарч буй өөрчлөлтүүд болон олон улсын харилцааны шинэ чиг хандлагууд, Орос, Монгол, Хятадын гадаад бодлого, гурван улсын хоёр болон гурван талын харилцаа зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Монгол улс, Монголын тал нутаг хоёр хөршийн геополитикийн ашиг сонирхлын мөргөлдөөний талбар байсаар ирсэн юм. Зөвхөн XX зууныг үечлэн авч үзвэл Монгол улс нь:

- 1911 он хүртэл Манж-Хятадын ноёрхолд байсан үе;
- 1921-1949 онд Хятадын капиталыг шахан зайлуулж Орос улс төр, эдийн засгийн нөлөөгөө идэвхжүүлсэн үе;
- 1949-1962 онд Орос, Хятадтай сайн хөршийн харьцаатай байсан ба энэ үед Монгол улс хамгийн хурдацтай хөгжсөн үе;
- 1962-1985 онд ЗХУ-аас бүрэн хамааралтай байж Хятадтай харилцаагаа зогсоосон үе;
- 1986-2002 онд Оросын улс төр, эдийн засгийн нөлөө буурч, Хятадын эдийн засгийн хүчин зүйл Монголд идэвхжих болсон үе гэж үзэж болох юм.

90-ээд оны сүүлээр ЗХУ задарч ЗХУ-аар толгойлуулсан дэлхийн социалист систем нуран унасан нь олон улсын харилцаанд шинэ үеийг нээсэн хэдий ч Монгол улсын хувьд авч үзвэл зөвхөн хойд хөршид өрнөсөн үйл явдал, социалист системийн задрал Монголд нөлөөлөөд зогсоогүй өмнөд хөрш улс төр, эдийн засгийн хямралаас гарч,

тогтвортой хөгжлийг олон энх тайванч гадаад бодлогыг эрхэмлэх болсон нь урд хөрштэй харилцаагаа сайжруулахад чухал хүчин зүйл болсон юм.

1980-аад оны дунд үеэс Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа сэргэж эхэлснээр хуучин ЗХУ-аас хараат байсан Монгол улсын гадаад бодлогод БНХАУ-тай харилцах харилцаа тодорхой байр суурийг эзлэх болсон юм. Энэ үйл явдалд 1978 оноос Хятадад хэрэгжих болсон өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого, ЗХУ-БНХАУ-ын харилцаа сайжирсан нь эергээр нөлөөлсөн нь дамжиггүй.

1982 онд хуралдсан ХКН-ын 12 дугаар Их хурлаас БНХАУ социалист орнуудтай харилцаагаа хэвийн болгохыг мэдэгдсэн, ЗХУ 1985 онд өөрчлөлт шинэчлэлт, ил тод байдлыг зарласан нь Монгол улсын гадаад бодлогод зарчмын өөрчлөлт хийх улс төрийн нөхцлийг бүрдүүлж өгсөн юм.

80-аад оны сүүлчээр ЗХУ болон түүний тэргүүлсэн социалист систем задрах нөхцөл бүрдэж, ЗХУ-ын удирдагч М.С.Горбачев 1986 онд Владивостокт, 1989 онд Бээжинд хийсэн айлчлалынхаа үеэр Монголын нутагт байрлаж буй цэргийн хүчээ татаж гаргахаа албан ёсоор мэдэгдсэн. 1991-1992 онуудад сүүлчийн цэргийн ангиуд Монголоос гарах үед олон тооны Оросын мэргэжилтэн, албан хаагчид Монголыг орхин одсон юм. Энэ үеэс Хятадын талын Монголд явуулах бодлого идэвхжиж, хоёр орны улс төрийн харилцаа сэргэж эхэлсэн.

1990-2002 оны хоорондох Орос-Монгол, Хятад-Монголын улс төрийн харилцааг үндсэнд нь хоёр ангилж болох юм.

I.1990- 1994 он:

1990-1994 онд Орос-Монголын улс төрийн харилцаа урьдын социализмын үеийн харилцаанаас эрс суларч ирсэн. 1991 онд БНМАУ-ын Ерөнхий сайд Я.Бямбасүрэн, 1993 онд Ерөнхийлөгч П.Очирбат нар ОХУ-д албан ёсоор айлчлал хийсэн ба ОХУ-аас Монгол улсад дээд хэмжээний албан ёсны айлчлал хийгдээгүй байна.

Тухайн үед Хятад-Монголын улс төрийн харилцаа зогсонги байдлаас эрчимтэй сэргэж

Хятадын талаас:

- 1991 онд БНХАУ-ын дарга Ян Шанкунь;
 - 1994 онд Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн Монгол улсад айлчилсан
- Монголын талаас:
- 1990 онд Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга П.Очирбат / 28 жилийн дараа/;
 - 1991 онд УБХ-ын дарга, дэд Ерөнхийлөгч Р.Гончигдорж;
 - 1992 онд Ерөнхий сайд Д.Бямбасүрэн;
 - 1994 онд Их Хурлын дарга Н.Багабанди нар харилцан айлчилсан.

Энэ үед Хятад-Монголын улс төрийн харилцаа Орос-Монголын улс төрийн харилцааг бодвол эрчимтэй хөгжиж, итгэлцлийг бэхжүүлж хоёр орны харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн юм.

90-ээд оны дунд үе хүртэл Орос-Монголын харилцаа суларсан нь Орос, Монголд улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт хийх болж багагүй бэрхшээлтэй тулгарч ирсэн ба "ах дүүгийн найрсаг харилцаанаас" олон улсын шинэ нөхцөлд зохицсон, хоёр орны харилцааны шинэ хэлбэрт шилжих арга замыг хайх шаардлага гарч ирсэнтэй холбоотой юм.

1991 оны "ЗСБНХОУ болон БНМАУ-ын найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны Тунхаг" нь Орос-Монголын харилцааны шинэ үеийн эхлэлийг тавьсан ба Тунхагт хоёр орон "олон улсын шинэ нөхцөл байдалд бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бэлэн байгааг" илэрхийлсэн. Ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ хэлбэрт шилжих, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхээр заасан.

1993 онд байгуулсан "ОХУ, Монгол улсын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ"-ээр 1966 оны "Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээ"-г шинэчлэн, хоёр орны харилцааны "холбоотны шинж чанарыг" өөрчилж, тэгш эрхтэй, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндсийг тавив.

1993 оны Орос-Монголын Гэрээ нь Орос-Монголын харилцааг эрчимжүүлэхэд төдийлөн түлхэц болоогүй бөгөөд уг гэрээнд гурав дахь оронтой хамтран хөрөнгө оруулалт хийхийг тусгасан нь Оросын Монгол дахь эдийн засгийн монополийг сулруулахад хүргэсэн.

1994 онд байгуулагдсан "Монгол улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ"-ээр, БНХАУ-Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэхээ илэрхийлсэн нь Монгол улсын Хятадаас болгоомжлох, үл итгэх байдлыг арилгах, хоёр орны хооронд итгэлцлийг бэхжүүлж, цаашид улс төр, эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах эрх зүйн үндсийг тавьж өгсөн юм.

II. 1995 - 2002 он:

Орос-Монголын харилцаа 1995 оноос эрчимтэй хөгжих эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. 1995 оны 4-р сарын 4-7-нд ОХУ, Монгол улсын Засгийн газрын тэргүүн нар хэлэлцээ хийж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны протокол болон хамтын ажиллагааны 10 баримтанд гарын үсэг зурав. / Черномырдин, Жасрай нар /

1996 оны Орос-Монголын албан ёсны Мэдээнд (коммюнике) гадаад худалдааны уналтыг зогсоох, худалдааны чөлөөт бүс байгуулах, гурван талын төсөл боловсруулах зэрэг эдийн засгийн харилцааг эрчимжүүлэхийг чухалчлан тусгасан байдаг. Хэдий тийм боловч Орос-Монголын эдийн засгийн харилцаа төдийлөн хурдацтай хөгжиж чадаагүй байсаар өдий хүрлээ.

90-ээд оны хоёрдугаар хагаст Хятад-Монголын дээд хэмжээний айлчлал үргэлжлэн явагдаж, 1997 онд БХАТ-ийн Байнгын Хорооны дарга Цяо Ши, 1999 онд БНХАУ-ын дарга Зян Зэминь Монгол улсад айлчилсан. Харин 2000 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин (26 жилийн дараа), 2002 онд ОХУ-ын Засгийн газрын тэргүүн М.М.Касьянов (31 жилийн дараа) Монгол улсад айлчлав.

1998 онд гаргасан "Монгол улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл", 2000 оны Орос-Монголын "Улаанбаатарын тунхаглал" нь хоёр орны

харилцааны үндсэн чиглэл, зорилтуудыг тодорхойлж өгсөн ба ойр ойрхон 2 жилийн зайтай гаргасан мэдэгдэл, тунхаглал нь хоёр хөрш Монгол улсад геополитикийн өндөр ач холбогдол өгч байгааг нотлох баримтууд юм.

Ийнхүү даяаршлын үед ОХУ, БНХАУ-аас Монгол улсын хувьд явуулж буй улс төрийн бодлого идэвхжиж, ялангуяа 90-ээд оны хоёрдугаар хагасаас Монгол улсад явуулах хоёр хөршийн бодлого тэнцвэржиж ирсэн гэж дүгнэж болох юм.

Орос-Монгол, Хятад-Монголын худалдаа, эдийн засгийн харилцаа

1991-2001 онд Орос-Монголын худалдааны нийт бараа эргэлт бараг 2 дахин буурсан нь худалдааны тариф, гаалийн татвар, тээврийн зардал, мөн манай экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалыг Оросын үйлдвэрүүдэд боловсруулах зардал өндөр байгаа зэргээс шалтгаалсан байна. Худалдааны тэнцлийн байдал Монголын талд ихээхэн алдагдалтай хэвээр байна.

Харин дээрх хугацаанд Хятад-Монголын нийт бараа эргэлт бараг 4,8 дахин өссөн. Экспортод эзлэх хувийн жин жилээс жилд өсч байна. Энэ нь Хятад, Монголын хооронд гадаад худалдааны тээврийг шуурхай болгох, үнийг хоёр талдаа 50% хүртэл бууруулах шийдвэр (1999 оны 7 сард) гаргасантай холбоотой юм.

Экспортын бараанд уламжлалт түүхий эдийн бараанаас гадна зэсийн баяжмал 88,9 %, молибден 98,4%, түүхий нефть 100%, хаягдал төмөр 98,9%, малын арьс, шир 98-100%, бохир ноолуур 98,6 хувийг эзэлж байна.¹

Хятад-Монголын худалдаа эрчимтэй хөгжиж байгаагийн нэг онцлог бол хилийн худалдаа юм. Хилийн 10 боомт ажиллаж байгаагаас улирлын чанартай 9 боомт бий. Энэ нь иргэдийг чөлөөт худалдаанд оруулж, худалдааны зохицуулалтыг орон нутаг бие даан хийх боломжийг олгосонтой холбоотой юм.

Орос-Монголын хооронд хил орчмын муж, хязгаар, бүгд найрамдах улсуудын удирдлага, тухайлбал Кемерово, Эрхүү муж, Бүгд найрамдах Буриад Улс, Чита мужийн захирагчидтай уулзалт хэлэлцээ явуулж байгаа боловч практик амьдрал дээр төдий л үр дүнд хүрэхгүй байна. Одоо Монгол-Оросын хил дээр 29 боомт үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 4 нь олон улсын зорчигч, ачаа тээврийн; 9 нь хоёр талын зорчигч, ачаа тээврийн; 9 нь түр буюу улирлын; 7 нь дамжин өнгөрөх зориулалттай байна. Гэвч дэд бүтэц сул хөгжсөн болон хоёр орны эдийн засгийн хөгжлийн чадавхи сул, эрх зүйн орчин бүрдээгүй зэргээс шалтгаалан зөвхөн Хиагт, Хандгайтын боомт л тохижоод байна. Хилийн ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээр 2000 онд байгуулагдсан. Хятад улстай харьцуулахад хилийн худалдаа өргөн явагдаж чадахгүй байна.

¹ Л.Бэгзжав. "Монгол - Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны зарим асуудал 1990 - 1999" УБ, 1999, 42-р тал

2001 оны байдлаар хөрөнгө оруулалттай компанийн тоогоор БНХАУ тэргүүлж байгаа бөгөөд (нийт 687 компани улсын бүртгэлд бүртгэгдсэн) ОХУ хоёрдугаарт орж (297 компани улсын бүртгэлд бүртгэгдсэн) байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ тэргүүлж байгаа ба 1990-2001 оны байдлаар нийт хөрөнгө оруулалт 136,9 сая ам.долларт хүрчээ.

ОХУ шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр 5-р байранд орж байгаа бөгөөд 1990-2001 оны байдлаар нийт 29.8 сая ам.долларын хөрөнгө оруулаад байна.

Хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрийн талаар

Орос-Монголын эдийн засгийн хамтын ажиллагаанд "Эрдэнэт", "Монголросцветмет" хамтарсан үйлдвэрүүд, "УБТЗ" хувь нийлүүлсэн нийгэмлэг чухал байр эзлэж байна. Эдгээр үйлдвэрүүд нь Монголын валютын орлогын 60 гаруй хувийг эзэлдэг бөгөөд Монголын эдийн засгийн чухал объектууд хэвээр байна. Оросын хөрөнгө оруулалт бүхий 297 аж ахуйн нэгж Монгол улсад ажиллаж байгаагаас 100 хувийн хөрөнгө оруулалттай "Зарубежстрой", "Бурводстрой", "Золотой Восток-Монголия", хамтарсан "Инком", "Эрдэнэтстрой" зэрэг компани 25,0 сая ам.долларын хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэв. Оросын томоохон хөрөнгө оруулалттай "Менатеп-СП" банк, "Альфа-Эко" компани төлөөлөгчийн газраа нээн үйл ажиллагаа явуулж эхлэв. Гэвч хөрөнгө оруулалтын хэмжээгээр ОХУ 5-р байранд орж байгаа нь бусад оронтой харьцуулахад харьцангуй удаашралтай байна.

Хятадын тал 1997 оноос хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлэх байр эзлэж байна. Хятадын талын хөрөнгө оруулалттай 687 аж ахуйн нэгж Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаагаас хамтарсан хөрөнгө оруулалттай 349, дагнасан хөрөнгө оруулалттай 84 компани байна. Үүнээс гол төлөв барилга байгууламжийн салбар, мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах салбар, хөнгөн үйлдвэр, худалдаа, нийтийн хоолны газар, хөдөө аж ахуй, газар тариалан, геологи, уул уурхайн салбарт оруулж буй хөрөнгө дийлэнх хувийг эзлэж байна. Гэвч Оростой харьцуулахад том салбарт том хөрөнгө оруулалт төдийлөн сайн хийгдэхгүй байна гэж үзэж болох байна. Зарим компаниуд татан буугдаж төдийлөн ашигтай ажиллаж чадахгүй байгааг ч бас тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Өр, зээлийн талаар

Орос-Монголын харилцаа шинэ хэлбэрт шилжсэн үеэс Монгол улс ОХУ-д төлөх өрийн асуудал яригдаж эхэлсэн. 70 жилийн "ах дүүгийн найрамдалт харилцаа", "Зөвлөлтийн ард түмний сэтгэл харамгүй тусламж"-ийн үр дүнд Монгол улс ОХУ-д 11 тэрбум ам.долларын өр төлөх болсон байна. ОХУ-ын Засгийн газрын тэргүүн 31 жилийн дараа Монгол улсад айлчлахдаа (2002 оны 3-р сард М.М.Касьянов) 11 тэрбум ам.долларын өрийг ОХУ-д төлөхийг албан ёсоор мэдэгдсэн. Оросын тал Орос-Монголын хамтарсан үйлдвэрт оруулах хувьцааг нэмэх замаар өрийг төлөх асуудал тавиад байгаа. Орос, Монголын 70 жилийн

харилцааны өр, зээлийн асуудлаас томоохон сургамж авах цаг болсон гэж дүгнэвэл зохино.

Хятадын талд төлөх өрийн тухайд 1958-1960 онд авсан зээлийн өрийн үлдэгдэл, хүүгийн хамт 28,3 сая шилжих рубль бий. Мөн худалдааны төлбөрийн 5,6 сая шв. франкийн өр төлөх асуудал 5 жилээр сунгагдаж байгаа. 1991-1994 онд олгосон 130 сая юанийн зээлийг 2006 оноос эхэлж төлнө.

Сүүлийн 10 жилд Оросын талаас Монголд үзүүлэх зээл эрс багассан байна.

- 1991 онд 48,97 сая ам.доллар

- 1992 онд 35,93 сая ам.доллар

/ 30 сая долларын зээл Ховдод цахилгаан станц бариулахаар олгосон, эрчим хүчний үнийг багасган жилд 5 сая ам.долларын хэмнэлт гаргасан, 2001 оноос эхлэн импортын зарим барааны гаалийн татвараа 10 орчим хувиар багасгасан/.

Хятадын талаас Монгол улсад үзүүлэх зээл эрс ихэссэн. Хятадын Засгийн газар:

- 1991 онд 50 сая юань (хүүгүй зээл)
- 1992 онд 30 сая (хүүгүй зээл)
- 1994 онд 50 сая юань (хүүгүй зээл)
- 1998 онд 100 сая юань (хөнгөлөлттэй зээл)
- 2000 онд 100 сая юань (хөнгөлөлттэй зээл)

90-ээд оноос хойшхи өр зээлийн асуудлыг авч үзэхэд Оросын урьдын болон Хятадын өнөөгийн өрийн дарамтанд Монгол улс бүрэн ороод байна.

Тусламжийн талаар

Сүүлийн 10 жилд Оросоос Монголд үзүүлэх тусламж бараг үгүй болж Хятадын талын тусламж идвэхжиж ирэв.

- 1991-1997 онд 42,6 сая юань /Засгийн газрын тусламж/
- 1998 онд 30 сая юань /Засгийн газрын тусламж/
- 1990 онд 30 сая юань /Засгийн газрын тусламж/
- 2000 онд 1 сая юань /Засгийн газрын тусламж/, 8 сая юань /БХЯ/
- 2001 онд 4 сая юань /зудын гамшгийг арилгахад 2 сая, шүлхийтэй тэмцэхэд 2 сая /Засгийн газрын тусламж/
- 2001 онд 50 сая юань /Засгийн газрын тусламж/

Түүнээс гадна ЭСЯ-ны мэдлийн тусламжийн сангаас жил бүр 1,2 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүлж байна. Хуучин ЗХУ-ын тусламжийн орыг одоо БНХАУ үзүүлэх боллоо.

Соёл, хүмүүнлэгийн салбарт

1990-ээд оны эхэнд Орос, Монголын соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа эрс хумигдаж байсан боловч сүүлийн жилүүдэд ОХУ-д боловсон хүчин бэлтгэх тухай хэлэлцээрүүд, Соёл, боловсрол, эрүүл мэндийн Яам болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах Протоколууд шинэчлэн байгуулагдаж, ялангуяа Бүгд найрамдах Буриад, Эрхүү, Кемеров мужтай боловсон хүчин харилцан сургах тухай Протоколууд байгуулав.

Одоогийн байдлаар Улаанбаатарт:

- Плехановын нэрэмжит Эдийн Засгийн Академи;
- Москвагийн эрчим хүчний их сургууль;
- Багшийн их сургууль;
- Дорнод Сибирийн Хүнсний Технологийн дээд сургууль;
- Кемеровын Их сургуулийн салбарууд ажиллаж байна.

ОХУ-д 1996 оноос жил тутам 60 хүртэл оюутан, 30 хүртэл аспирант, докторантыг Монгол улсаас сургадаг байснаа 2002-2003 оны хичээлийн жилд дээрх тоог 150 болтол нэмсэн / 90 оюутан, 60 аспирант/. Ерөнхийлөгчийн тэтгэлгээр жил бүр 130 оюутан (80 оюутан, 50 аспирант, магистр) ОХУ-ын их, дээд сургуульд сургаж байна. Одоо 477 оюутан, аспирант Засгийн газар хоорондын хэлэлцээрээр, 500 орчим оюутан хувийн зардлаар ОХУ-д сурч байна. Гэвч шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах зэрэг салбарын хамтын ажиллагаа удаашралтай байна.

БНХАУ, Монгол улсын хооронд боловсролын салбарт хамтран ажиллах 1989 оны гэрээгээр БНХАУ-д монгол хэл заах цөөн тооны багш ажиллуулж 15 оюутан сургаж эхэлсэн. 2000 онд 50 орчим оюутан, мэргэжил дээшлүүлэгч солилцож ирлээ. Хувиараа суралцагчдын тоо ч өсч байна.

Боловсролын салбарт 5 жилийн хугацаатай хамтран ажиллах 2 удаагийн төлөвлөгөөг хэрэгжүүлээд байна. Шинжлэх ухааны салбарын харилцаа Засгийн газрын 5 жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, эрдэмтдийн дунд уулзалт, семинар зохисон байгуулагдаж, шинжлэх ухааны байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтож байна.

Эрүүл мэндийн салбарт олсон том амжилт бол Монголын иргэдийг хөнгөлөлттэй тарифаар эмчилж байх тохиролцоонд хүрсэн нь ач холбогдлоо өгч монголчууд урд хөршид очиж эмчлүүлэх өргөн боломжийг бүрдүүлж байна. (1999 онд эрүүлийг хамгаалах салбарт хамтран ажиллах гэрээнд БНХАУ-д эмчлүүлэх шинэ тариф тогтоож өгсөн). 2001 онд 33000 иргэд БНХАУ-д эмчлүүлэх зорилгоор явсан байна.

Эцэст нь товчхон дүгнэхэд 90-ээд оны дунд үе хүртэл Орос-Монголын улс төр, эдийн засаг, бусад салбарын харилцаа эрс хумигдаж, Хятад-Монголын харилцаа зогсонги байдлаас эрчимтэй сэргэн хөгжиж ирсэн.

90-ээд оны дунд үеэс хойш Орос-Монгол, Хятад-Монголын харилцаа тэнцвэртэй хөгжиж байна. Орос-Монголын харилцаа улс төр, дипломатын хүрээнд амжилттай явагдаж байгаа ч эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах зэрэг салбарт удаашралтай хэвээр байна. Хэдий тийм боловч Орос улс Монголын эдийн засгийн чухал объектуудад томоохон хөрөнгө оруулж Монголын эдийн засгийн салбарт чухал байр суурийг эзэлсэн хэвээр байна.

Хятад-Монголын худалдаа, эдийн засгийн харилцаа эрчимтэй хөгжиж байгаа ч Хятадын талын томоохон хэмжээний хөрөнгө оруулалт бүхий объектууд үгүйлэгдэж байна.

Монгол улс дэлхийн интеграцчилалд татагдан орж буй өнөөгийн нөхцөлд Орос, Хятадын Монголд явуулах геополитик, гео эдийн засгийн сонирхол идэвхжиж, өрсөлдөж байгаа хэдий ч Орос-Хятадын түншлэлийн харилцаа гүнзгийрч байгаа нөхцөлд Монгол улсыг "илбэн барих" бодлого явуулахыг үгүйсгэж болохгүй юм.

The report analyses Russian Mongolian and Chinese Mongolian political, economical and other relations in the 90ies. It states that relations with two neighbours are equally developing. It is noted in the report that although Russian Mongolian political and diplomatic relations are favorably, developing the pace of economic scientific and cultural ties are lagging behind. At the same time Russia is investing increasing amount of money into the Mongolian economy.

The report emphasizes that the Chinese Mongolian trade and economic development issues are on rise but there is still a lot to be done for the Chinese investment injection. In the rapidly developing world Mongolia is playing important role in the Chinese and Russian geopolitics and geo-economics.